

БАЙГУУЛЛАГЫН
БАЙГУУЛЛАГЫН НЭРИЙН ӨӨРЧЛӨЛТ

Аж үйлдвэрийн явдлын яамны дэргэд Барилгын хэлтэс
Барилгын цэргийн салбар
Аж үйлдвэр ба барилгын яам
Дотоод яамны дэргэд барилгын хэлтэс
Олзлогдсон цэргүүдийн хэргийг эрхлэх ерөнхий газар
Барилгын хэрэг эрхлэх ерөнхий газар
Барилгын хэрэг эрхлэх хороо
Барилга, барилгын материалын үйлдвэрийн яам
Барилга, эдийн засгийн комисс
Улсын барилгын эдийн засгийн комисс
Барилгын зөвлөл; Барилгын яам; Барилга, барилгын
материалын үйлдвэрийн яам
Улсын барилгын зөвлөл
Барилга, барилгын материалын үйлдвэрийн яам Улсын барилгын хороо Барилгын
яам
Барилга, хот байгуулалтын яам
Дэд бүтцийн хөгжлийн яам
Дэд бүтцийн яам
Барилга, хот байгуулалтын яам
Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам
Барилга, хот байгуулалтын яам

Нэг. Байгууллагын түүх

Манай оронд 1921 онд ардын хувьсгал ялснаар Улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэхэд үйлдвэр, аж ахуй, соёлын салбарыг үүсгэн барьж байгуулахад барилга байгууламжийн ажлыг аль болохоор хөгжүүлэхийн чухлыг нам засгаас анхаарч ирсэн байна. Нам, засгийн шийдвэрээр 1940-өөд оноос эхлэн Дотоод яамны дэргэд барилгын хэлтсийг байгуулан ажиллаж эхэлжээ.

Ардын засгийн газрын 1926 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн IV хурлын тогтоолоор Аж ахуйн явдлын яам, харилцан туслах хоршоолол, Монгол, банкыг түшиглүүлэн “Монголын хувь нийлүүлсэн хоршоо”-г буман төгрөгийн хөрөнгөтэйгээр байгуулсан нь монголын барилгын байгууллагын үүсэл байв. Тус хоршоо нь барилга, барилгын материал үйлдвэрлэх ажлыг хослон гүйцэтгэж байв.

1926 оны 10 дугаар сард хуралдсан Ардын засгийн газрын хурлын 40 дүгээр тогтоолоор “Барилгын ажлыг эмх цэгцтэй болгох, төвлөрсөн удирдлагаар хангах, төвлөрсөн хяналтай болгох” гэсэн зорилтыг хэрэгжүүлж Аж ахуйн явдлын яамны дэргэд “Барилгын хэлтэс” байгуулж, барилга барих, барилгын материал үйлдвэрлэх, зураг төсөл зохиох ажлыг эрхлүүлсэн байна. Үүний үр дүнд 1927 онд УБ хотын зүүн дүүрэгт Улаанхуарангийн тоосгоны завод, 1928 онд Ерөөгийн заводыг ашиглалтад оруулж, “Барилгын хэлтсийн” мэдэлд харъяалуулж байжээ.

Монголын барилгын салбарт онцгой үүрэг гүйцэтгэсэн том байгууллагын нэг нь барилгын цэргийн салбар бөгөөд 1936 оны 3 дугаар сард Цэргийн яамны сайд, бүх цэргийн жанжин, маршал Г.Дэмидийн санаачлага шийдвэрээр барилгын цэргийн салбарыг байгуулсан байна.

БНМАУ-ын СнЗ-өөс хувь нийлүүлсэн барилгын хоршоог аж ахуй, зохион байгуулалтын хувьд бэхжүүлж, 1936 оны 11 сард хуралдсан БНМАУ-ын СнЗ-ийн 45-р хурлын тогтоолоор Худалдаа, аж үйлдвэрийн яамны дэргэд “Барилгын техникийн хэрэг эрхлэх газар”-ыг байгуулжээ. Ингэж барилгын байгууллага нь хоршооллын сектороос улс ардын аж ахуйд бие даасан барилгын үйлдвэрлэлийн салбар болон хөгжих бололцоо бүрдсэн байна. Үүний дараагаар “Барилгын техникийн хэрэг эрхлэх газар”-ыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 12 сарын 17-ны өдрийн 33-р тогтоолоор “Улсын барилгын трест” болгон өөрчилсөн байна.

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1937 оны 12 сарын 24-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор Худалдаа, аж үйлдвэр, зам тээвэр, харилцан нэвтрэлцэх холбооны яамны аж төрлийн чиглэлээр гурав салгаж, “Аж үйлдвэр ба барилгын яам”, “Худалдаа тээврийн яам”, “Харилцан нэвтрэлцэх ерөнхий газар” болгон өөрчлөн зохион байгуулжээ. 1938 онд зураг төслийн контор, 1940 онд СнЗ-ийн 4-р тогтоолын заалтын дагуу Аж үйлдвэр, барилгын яамны дэргэд Барилгын зураг төсөл, барилгын төсөв үйлдэх, барилгажилтын төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий “Барилгын зураг төсөв, төлөвлөгөөний газар”-ыг байгуулж 1940 онд “Улсын барилгын трест”-ийг Дотоод явдлын яамны мэдэлд шилжүүлжээ. Дайн дуусаж, энх цагийн бүтээн байгуулалтын ажил эрчимтэй хийгдэх шаардлага тавигдаж байсан тэр үед олзлогдсон Япон цэргүүдийн хүч хөдөлмөр, чадварыг бүтээн байгуулалтад ашиглах зорилгоор СнЗ-ийн 1945 оны 10-р сарын 12-ны өдрийн 75-р тогтоолоор СнЗ-ийн дэргэдэх Олзлогдсон цэргүүдийн хэргийг эрхлэх ерөнхий газар байгуулжээ. Дайны

жилүүдэд /1941-1945 онд/ улсын хэмжээгээр барилгын ажлын хэмжээ 116 сая төгрөг хүрээд байв. Ийнхүү 1931 - 1945 онд барилгын улс ардын аж ахуйн салбар болж хөгжив. 1946 онд "Барилгын материал бэлтгэх газар"-ыг байгуулжээ. Энэ үед жилд 3.3 сая ширхэг тоосго, 500 шоо метр бетон болон төмөр бетон эдлэл, 2000 гаруй тонн шохой үйлдвэрлэж байсан байна.

Барилгын байгууллагыг мэргэжилтэй ажилтан, ажилчнаар хангах шаардлага хүчтэй тавигдсан учраас цэргийн албанаас халагдсан цэргийн дарга нарыг хүлээн авч барилгын ажилд түргэвчилсэн сургуулиар сургах, илгээлтээр ажилчин элсүүлэх ажил эрчимтэй өрнөж тухайн салбарт мэргэжилтэн бэлтгэх эхлэлийг тавьжээ.

Барилгын ажил цаашид нэмэгдсэнээр 1947 оны 11 сарын 4-ний өдрийн МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын СнЗ-ийн 60/26 дугаар хамтарсан тогтоолоор "Олзлогдсон цэргүүдийн хэрэг эрхлэх газар"-ыг өөрчлөн "Барилгын хэрэг эрхлэх ерөнхий газар"-ыг байгуулжээ. Шинээр байгуулагдсан энэ ерөнхий газрыг яам эрхтэйгээр ажлаа явуулах нь зүйтэй гэж шийдвэрлэжээ.

БНМАУ-ын СнЗ-ийн 1956 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 22-р тогтоолоор "Барилгын хэрэг ерөнхий газрын орон тоо сарын цалингийн хэмжээг баталж өгсний дараагаар дээрх газрын харъяанд БНМАУ-ын СнЗ-ийн 1956 оны 04-р сарын 26-ны өдрийн 326-р тогтоолоор 40 мянгатын контор байгуулахыг зөвшөөрч, орон тооны нэгжийг баталж өгсөн байна.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1959 оны 11 сарын 04-ний өдрийн 182 дугаар зарлигаар БНМАУ-ын Барилга, барилгын материалын үйлдвэрийн яам байгуулж 1959 оны 11 сарын 11-нд БНМАУ-ын СнЗ-ийн 425 дугаар тогтоолоор "Барилга, барилгын материалын үйлдвэрийн яамны зохион байгуулалт, орон тоо, цалингийн хэмжээг өөрчлөн баталсан байна.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1959 оны 11-р сарын 04-ний өдрийн 184-р зарилгаар Тус улсын бүх төрлийн барилгын ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, төвлөрсөн хяналт шалгалтыг хүчтэй болгох зорилгоор БНМАУ-ын СнЗ-ийн Улсын Барилгын комисс"-ыг байгуулжээ.

1960-аад оны эхээр манай улсын барилгын хөгжилтөд ЗХУ-ын ах дүү социалист орнуудын техник эдийн засгийн талаар үзүүлэх тусламж, урьд онуудыг бодвол эрч нэмэгдсэн юм. Энэ байдлаас үүдэн Улсын барилгын комиссын зохион байгуулалтад өөрчлөлт орох шаардлагатай болсон байна. Иймээс МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын СнЗ-ийн 1960 оны 12 сарын 20-ны өдрийн хамтарсан хурлын 526/364 дугаар тогтоолоор Гадаад орнуудтай эдийн засгийн талаар харилцах улсын хороог, Улсын барилгын комисстой нэгтгэн БНМАУ-ын СнЗ-д "БНМАУ-ын Барилга, эдийн засгийн комисс"-ыг байгуулж, комиссын орон тоо, цалингийн талаар БНМАУ-ын СнЗ-өөс 1961 онд 648, 1962 онд 277 дугаар тогтоол гаргажээ. Энэ тогтоол нь тухайн үед уг комиссын ажлын уялдаа, шаардлагыг бүрэн хангаж байсан боловч зарим талаар шинэчилэн өөрчлөлт оруулах шаардлага зүй есоор гарч ирлээ. Энэ байдлыг БНМАУ-ын СнЗ харгалзан үзэж 1963 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 323-р тогтоолоор "Улсын барилга эдийн засгийн комиссын зохион байгуулалт орон тоо, цалингийн фонд"-ыг шинэчлэн баталжээ.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1965 оны 11-р сарын 26-ны өдрийн 234-р зарлигаар Барилгын үйлдвэрүүдийг удирдах шат дамжлагыг багасгаж, удирдлагыг төвлөрүүлэн сайжруулах зорилгоор БНМАУ-ын Барилгын яамыг татан буулгаж, түүний харьяа барилгын гүйцэтгэгч байгууллагуудыг удирдах удирдлагыг БНМАУ-ын Барилгын зөвлөлд шууд харъяалуулсан байна. Ийнхүү Барилгын яамыг тухайн үед татан буулгасан боловч, Барилгын материалын үйлдвэрийн яам нь хэвээр үлдэж, 1968 он гартал үйл ажиллагаа явуулж байжээ. Гэвч барилгын материалын үйлдвэрийн хөгжилт удаан явцтай байв. Ийм байдалд дүгнэлт хийснээр Барилгын яам, Барилгын материалын үйлдвэрийн яам, БНМАУ-ын Улсын барилгын зөвлөлийг татан буулгаж дахин БНМАУ-ын Барилга, барилгын материалын үйлдвэрийн яамыг байгуулсан байна.

1972 онд БНМАУ-ын СнЗ-ийн дэргэд улсын хэмжээнд барилга техник хяналтын бодлого үйл ажиллагааг эрхлэх үүрэг бүхий Барилга Архитектурын Комиссыг байгуулж, БНМАУ-ын СнЗ-ийн 1972 оны 06 дугаар 09-ний 222 дугаар тогтоолоор Барилга, архитектурын комиссын харъяа Улсын барилга, техникийн байцаан шалгах газрыг Улсын барилга, уул техникийн байцаан шалгах газар болгож өөрчлөн зохион байгуулав.

1981 онд Барилга архитектурын комиссыг Барилга-архитектур, техник байцаан шалгах газрыг Улсын барилга, уул техник хяналтын улсын хороо болгож өөрчлөв. Тус хорооны зохион байгуулалт, орон тоог БНМАУ-ын СнЗ-ийн 1981 оны 01 дүгээр сарын 31-ний 42 дугаар тогтоолоор Улсын барилгын шалган байцаах газар, Улсын уул техник, эрчим хүчний хяналтын газар гэсэн 2 газартай байхаар тогтоожээ.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1983 оны 66 дугаар тогтоолоор барилгын үйлдвэрлэлийг угсармалжуулах, шинэ хийц бүтээц нэвтрүүлэх зорилгоор ББМҮЯ-нд барилгын хийц хэсгийн хэлтсийг байгуулсан байна.

МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1984 оны 209 дүгээр тогтоолыг үндэслэн БНМАУ-ын СнЗ-ийн 1984 оны 8-р сарын 15-ны өдрийн 239 дүгээр тогтоолоор ББМҮЯ-ны зохион байгуулалт, орон тоонд зарим өөрчлөлт оруулсан байна.

БНМУ-ын Сайд нарын Зөвлөлөөс тогтоохдоо, ББМҮЯ-ны зохион байгуулалтын бүтцэд барилгын материалын үйлдвэрийг удирдах ерөнхий газар байгуулж, аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллуулахыг заагаад Барилгын материалын үйлдвэрийг удирдах ерөнхий газрын зохион байгуулалтыг баталсан байна.

МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1986 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 250 дугаар тогтоолоор Барилга, барилгын материалын үйлдвэрийн яамыг татан буулгаж БНМАУ-ын Улсын барилгын хороо байгуулжээ. 1989 онд Улсын барилгын хороог өөрчлөн Барилгын яам нэртэй болсон байна.

1965-1989 он Барилгын материал техникийн Бааз суурь бэхжсэн, улс ардын аж ахуйн тэргүүлэх салбар болов.

Монгол оронд ардчилсан хөдөлгөөн үүсч улс орон нийгмийн амьдралыг ардчилсан замаар өөрчлөн шинэчлэх хөдөлгөөн барилгын салбарыг тойрсонгүй. Гадны зээл тусламжийн болон улсын төсвийн хөрөнгө оруулалт зогсож, барилгын байгууллагууд ажилгүйдэж, барилгачид цомхотголд орж эхлэв.

1990 оны 06-р сарын 24-нд Монголын барилгачдын анхдугаар их хурал хуралдаж “Их барилгын салбарыг өөрчлөн шинэчлэх үзэл баримтлал”-ыг баталжээ.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газрын 1990 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 13 дугаар тогтоолоор Барилга, хот байгуулалтын талаар улсын нэгдсэн бодлого явуулах, барилгын салбарын норм, норматив боловсруулах ажлыг зохион байгуулж тэдгээрийг хянаж батлах үүрэг бүхий “Барилга хот байгуулалтын комисс”-ыг Засгийн газрын дэргэд байгуулж ажиллуулав.

Тус комисс тэр үед хувьчлалыг зөв гольдролоор цаг алдалгүй явуулах, барилгачдыг шинэ нөхцөл байдалд ажиллуулах мэдлэг оюуны бэлтгэлийг хангахад үйл ажиллагаа чиглүүлж байв. Гэвч удалгүй Монгол Улсын Засгийн газрын 1992 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 12 дугаар тогтоолоор “Барилга хот байгуулалтын яам”-ыг байгуулж орон тоо, цалингийн санг баталж, Барилга, хот байгуулалтын комиссыг татан буулгажээ.

Шинэ яам Хүн амын нутагшил хөгжлийн ерөнхий төсөл, баруун бус нутгийг хөгжүүлэх төсөл, Монгол улсын Барилгын тухай, Хот байгуулалтын тухай хуулийн төсөл зэргийг боловсруулах ажлыг хийж эхлэв.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж Барилга, хот байгуулалтын яам, Зам, тээвэр, холбооны яамыг татан, буулгаж энэ хоёр яамыг нэгтгэн “Дэд бүтцийн хөгжлийн яам”-ыг байгуулж Засгийн газрын 1994 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор орон тоо, цалингийн санг баталсан байна. Дэд бүтцийн хөгжлийн яамны бүтцийг доорх бүтэцээр батлав.

а/ Тээврийн газар

б/ Холбооны газар

в/ Архитектур хот байгуулалт орон сууц нийтийн аж ахуйн газар

г/ авто замын газар

д/ барилга, барилгын материалын үйлдвэрийн газар

е/ барилга, техник ашиглалтын хяналтын газар

ё/ тамгын газар

ж/ эдийн засаг, хамтын ажиллагааны хэлтэс

з/ техник, технологийн мэдээллийн хэлтэс гэсэн бүтэцтэй байв.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 1994 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор яам, тусгай газрын нийтлэг дүрэм, тэдгээрийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг баталсан. Үүнд:

Барилга, барилгын материалын үйлдвэрлэл, хот байгуулалт, геодези, зураг зүй, орон сууц, нийтийн аж ахуй, зам, тээвэр, холбооны салбарын хэтийн болон ойрын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, төр, засгийн газраас тухайн шатанд баримтлах бодлого, үндсэн чиглэлийг боловсруулах.

Дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх арга зам, дарааллыг хөрөнгө хүчний боломж, нийтийн шаардлагад уялдуулан зохицуулж хэрэгжүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

Салбарт зах зээлийн харилцааг төлөвшүүлэх, дэд бүтцийн зохистой хөгжлийг хангахад чиглэсэн шударга өрсөлдөөн өрнүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт хийх зэрэг асуудлаар Засгийн газрын баримтлах бодлогыг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

Барилга угсралт, замын ажил, бүх төрлийн тээвэр, холбооны үйлчилгээ, барилгын материалын үйлдвэрийн бүтээгдэхүүн, зураг төслийн ажлын чанарын түвшин, үндсэн тоног төхөөрөмж, хэрэгсэл байгууламжийн ашиглалтад тавих мэргэжлийн улсын хяналтыг хэрэгжүүлж, улсын экспертизийн дүгнэлт шийдвэр гаргаж, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангуулах.

Монгол орон хүн амын нутагшил, суурьшил болон бус нутгийн төлөвлөлт, хот суурин газрыг барилгажуулах ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг байгаль орчныг хамгаалах бодлоготой уялдуулан холбогдох яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, хот тосгоны захирагчтай хамтран зохион байгуулах.

Монгол орны өвөрмөц онцлог, зах зээлийн харилцаанд нийцүүлэн хот байгуулалт, архитектур төлөвлөлтийн шийдлийн түвшинг дээшлүүлэх, үндэсний уран барилгын өв уламжлалыг сэргээн хөгжүүлэх.

Салбарын чиглэлээр зураг төсөл, судалгааны ажлыг хөгжүүлж, техник, технологийн дэвшлийг хангах.

Ийнхүү нийгмийн шинэ харилцааны хандлага чиглэлийг тодорхойлох, хувийн өмчийн хэлбэрт шилжих ажлууд хийгдэж байв.

Энэ үе буюу 1991-1995 он барилгын салбарын үйл ажиллагаа үндсэндээ зогсолтод орсон үе байв.

1996 онд Монгол Улсын Засгийн газар өөрчлөгдсөний дараа Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн 182 дугаар тогтоолоор яамны бүтцэд өөрчлөлт орж зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсан.

- а/ эдийн засаг, хамтын ажиллагааны газар
- б/ хот байгуулалт, орон сууц, нийтийн аж ахуйн газар
- в/ барилга, барилгын материалын үйлдвэр газар
- г/ холбооны газар
- д/тээврийн газар
- е/ авто замын газар
- ё/ аялал жуулчлалын газар
- ж/ эрчим хүчний газар
- з/ түлшний газар
- и/ тамгын хэлтэс гэсэн бүтэц ажиллах болсон.

Энэ үед барилгын салбарын техникийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Барилга архитектурын газар”-ыг Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 300-р тогтоолоор байгуулсан байна.

1996 оноос барилгын үйлдвэрлэл сэргэх хандлагатай болж хувийн хөрөнгө оруулалттай контор, үйлчилгээний зориулалттай жижиг барилгууд баригдах болов. Мөн нийслэлийн төв гудамжууд дахь орон сууцны 1 дүгээр давхрыг дэлгүүр, гуанз, үйлчилгээний зориулалтаар өөрчлөн засварлах ажил эрчимтэй өсөв.

Засгийн газрын 1999 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 28 дугаар тогтоолоор ДБХЯ-ны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталсан байна.

2000 оны сонгуулийн үр дүнд байгуулагдсан УИХ Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан ДБХЯ нь Дэд бүтцийн яам гэсэн нэртэй чиглэлийн яам болсон. Засгийн газрын 2000 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 131 дүгээр тогтоолоороо яамдын зохион байгуулалтын бүтцийг өөрчлөн дор дурдсанаар баталсан.

- а/ Түлш, эрчим хүчний бодлого, зохицуулалтын газар
- б/ Зам, тээвэр, мэдээлэл, холбоо, аялал, жуулчлалын бодлого, зохицуулалтын газар
- в/ Барилга, хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газар
- г/Төрийн захиргааны удирдлагын газар /Хамтын ажиллагааны хэлтэстэй/
- д/ Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар

Засгийн газрын 2000 оны 9-р сарын 6-ны өдрийн 139-р тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар”- ыг байгуулжээ.

Улсын Их Хурлын 2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн Засгийн газрын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Барилга, хот байгуулалтын яам байгуулагдаж тус яамыг чиглэлийн яамаар тодорхойлж, сайд нь засгийн газрын гишүүн байхаар зааж дор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ:

-барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн асуудал;

-хот байгуулалт, архитектурын асуудал;

-орон сууцны бодлогын асуудал;

-нийтийн аж ахуйн асуудал ;

-барилгажих талбай, газрын асуудал ;

-газар зохион байгуулалтын удирдлага,геодези. зураг зүй, үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 201 дүгээр тогтоолоор Барилга, хот байгуулалтын яамны зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталсан. Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5, Засгийн газрын агентпагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6.3- ыг үндэслэн Барилга, хот байгуулалтын яамны зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталжээ.

а/Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газар /Нутагшилт, суурьшлын хэлтэстэй/;

б/Газрын харилцаа, эрхийн бүртгэлийн бодлого, зохицуулалтын газар

/Газар өмчлөлийн хэлтэстэй/;

в/Барилга, нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газар

/Орон сууцны зээлийн хэлтэстэй/;

г/Төрийн захиргаа, удирдлагын газар.

Яамны орон тооны хязгаарыг 80, зардлын төсвийн хязгаарыг 318.0/ гурван зуун арван найм/ сая төгрөг байхаар тогтоож өгсөн.

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт Барилга, хот байгуулалтын сайдын болон Засгийн газрын танхимын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, төрийн захиргааны удирдлага, хэрэгжилтийг зохицуулалтаар хангах, эдийн засаг, хяналт - шинжилгээ хийх үр дүнг үнэлэх асуудлыг хамарсан Барилга, хот байгуулалтын яамны стратеги болон бүтцийн загварыг тодорхойлов.

Хөтөлбөрийг УИХ-ын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн “Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг үндэслэв.

УИХ-ын 2004 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 14 тогтоолоор Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар /агентлаг/ -ыг мөн Засгийн газрын 2004 оны 201 дүгээр тогтоолоор “Барилга, нийтийн аж ахуйн хөгжлийг дэмжих төв”-ийг “Барилга хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар”-ын суурин дээр байгуулсан.

Барилга, хот байгуулалтын сайдын 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 08 дугаар тушаалаар Барилга, нийтийн аж ахуйн хөгжлийг дэмжих төвийн зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсан.

а/ Барилгын хэлтэс

б/ Нийтийн аж ахуйн хэлтэс

в/ Нормчлолын хэлтэс

г/ Захиргаа, үйлчилгээний хэлтэс

Дэд бүтцийн ажилтны мэргэжил дээшлүүлэх институтийг 2005 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Барилга, хот байгуулалтын яамны харъяалалд салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, мэргэжлийн ур чадварын

шалгалт зохион байгуулах бодлого, үйл ажиллагаа явуулах үүрэгтэйгээр байгуулсан.

Дэд бүтцийн ажилтны мэргэжил дээшлүүлэх институтийн Удирдах зөвлөлийг 2005 оны 03 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 27 дугаар тогтоолоор яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрч, зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсан.

- а/ Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газар;
- б/ Газрын харилцаа, эрхийн бүртгэлийн бодлого, зохицуулалтын газар;
- в/ Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газар;
- г/ Санхүү, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны газар;
- д/Төрийн захиргааны удирдлагын газар /Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэстэй/.

Барилга, хот байгуулалтын яам нь Засгийн газрын барилга, хот байгуулалтын зөвлөхийн үүрэг гүйцэтгэх болсон. Барилга, хот байгуулалтын яамны орон тооны хязгаарыг 70 байхаар тогтоов.

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт Барилга, хот байгуулалтын сайдын болон Засгийн газрын танхимын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, төрийн захиргааны удирдлага, хэрэгжилтийг зохицуулалтаар хангах, эдийн засаг, хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх асуудлыг хамарсан Барилга, хот байгуулалтын яамны стратеги бүтцийн загварыг тодорхойлов.

Хөтөлбөрийг УИХ-ын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн “Монгол Улсын Төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг үндэслэв.

Барилга, хот байгуулалтын яам нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үүрэг хүлээж Барилга, хот байгуулалтын сайд, Засгийн газрын танхимд бүх талын зөвлөгөө дэмжлэг үзүүлнэ. Барилга, хот байгуулалтын яам салбарын бодлогын удирдамжаар хангах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан салбарын зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, уялдуулан зохицуулах, бодлого шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, салбарын харилцан уялдаа холбоог хангах асуудалд өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад анхаарал төвлөрүүлэхээр болжээ.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Монгол Улсын Иргэний хуулийн 31 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2006 оны “Төв байгуулах тухай” 37 дугаар тогтоолыг үндэслэн Барилга, хот байгуулалт нийтийн ахуйн хөгжлийг дэмжих төвийг Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн үндэсний төв болон өөрчлөн байгуулсан.

Засгийн газрын 2006 оны 37 дугаар тогтоолоор “Хот байгуулалт” улсын уйлдвэрийн газрыг, “Барилга, нийтийн аж ахуйн хөгжлийг дэмжих төв”-тэй нэгтгэн

Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн үндэсний төв"-ийг байгуулсан бөгөөд Дэд бүтцийн ажилтны мэргэжил дээшлүүлэх институтийг тус төвд нэгтгэн Барилга, хот байгуулалтын сайдын 2006 оны 04 дүгээр сарын 24-ний 64 дүгээр тушаалаар төвийн бүтэц, зохион байгуулалтыг дор дурдсанаар баталсан.

- а/ Захиргаа, санхүүгийн хэлтэс
- б/ хот байгуулалт, зураг төслийн хэлтэс
- в/ Нийтийн аж ахуйн хэлтэс
- г/ Норм, нормативын хэлтэс
- д/ Барилга, барилгын материалын хэлтэс
- е/ Сургалт, судалгаа мэдээллийн төв

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн Барилга, хот байгуулалтын сайдын 2006 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 134 дүгээр тушаалаар Засгийн газрын тохируулагч агентлагч Газрын харилцаа, геодези зураг зүйн, газрын бүтцийг дор дурдсанаар баталсан.

- а/ Газар зохион байгуулалтын хэлтэс
- б/ Геодези, зураг зүйн хэлтэс
- в/ Кадастрын хэлтэс
- г/ Захиргааны хэлтэс
- д/ Санхүү, аж ахуйн хэлтэс
- е/ Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс

Газрын мэдээллийн сангийн үндэсний төвтэй, аймаг, нийслэлд Газрын албатай байхаар Засгийн газрын тухай Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн Барилга, хот байгуулалтын сайдын 2006 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 135 дугаар тушаалаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын бүтцийг дор дурдсанаар баталсан.

- а/ Захиргаа, удирдлагын хэлтэс
- б/ Санхүү аж ахуйн хэлтэс
- в/ бүртгэлийн хэлтэс
- г/ Архив мэдээллийн сангийн хэлтэс
- д/ Хяналт шинжилгээний хэлтэс

Орон нутагт Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн албатай. Барилга, хот байгуулалтын сайд, Сангийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2006 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 196/372/567 дугаар хамтарсан тушаал, захирамжаар Орон сууцны санхүүжилтийн корпораци хязгаарлагдмал хариуцпагатай компанийг үүсгэн байгуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн хуулинд өөрчлөлт орж Барилга, хот байгуулалтын яам, Зам, тээвэр, аялал жуулчлалын яамыг татан буулгаж Зам, тээвэр, барилга хот байгуулалтын яам болгон өөрчилсөн.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 65 дугаар тогтоолоор Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны бүтцийг дор дурдсанаар баталсан.

- а/ Зам, тээврийн бодлогын газар;
- б/ Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын газар;
- в/ Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газар;
- г/ Төрийн захиргааны удирдлагын газар;
- д/ Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Хамтын ажиллагааны хэлтэс/;
- е/ Хяналт, шинжилгээ үнэлгээний газар

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 63 дугаар тогтоолоор тус яам Барилга, хот байгуулалтын яам нэртэй болж өөрчлөгдсөн.

Эрхлэх асуудлын чиглэлээр 6 газар 2 хэлтэстэй үйл ажиллагаа явуулж байгаад Засгийн газрын 2016 оны 12-р сарын 28-ны өдрийн 216-р тогтоолоор 2017 онд Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар шинээр нэмэгдэж байгуулсан. Одоогоор 7 газар 4 хэлтэстэй үйл ажиллагаа явуулж байна.

Хоёр.Баримтын түүх

Барилга, барилгын материалын үйлдвэрийн яамны архивын 1940-1971 оны дуустлах баримт бичгийг Улсын Түүхийн төв архивын тооцооны групптэй гэрээ хийж цэгцлүүлсэн байна. Тус яамны архивын баримтыг 3 фондод хувааж цэгцэлсэн байна. Үүнд:

1. СнЗ-ийн дэргэдэх Олзлогдсон цэргүүдийн хэрэг эрхлэх газар
2. Улсын барилгын зөвлөл
3. Барилга, барилгын материалын үйлдвэрийн яам.

Харин 1964 онд байсан Барилга, барилгын материалын үйлдвэрийн яамны баримт нь Ой модны аж үйлдвэрийн яаманд байгаа учир цэгцлэгдээгүй байна. Тус яамны байнга хадгалагдах 1-р бүртгэлээр 709 хадгаламжийн нэгж, 2-р бүртгэлээр 778 хадгаламжийн нэгж буюу нийт 1587 хадгаламжийн нэгж нь Түүхийн төв архивын 275-р хөмрөгт хадгалагдаж байна.

Барилга, барилгын материалын үйлдвэрийн яамны 1958-1981 оны баримт бичгийг тус яамны архивын эрхлэгч Д.Лхагвасүрэн цэгцэлж Улсын архивын хэрэг эрхлэх газрын дэргэдэх баримт бичиг магадлан шалгах комиссын 1983 оны 07-р сарын 01-ний өдрийн хурлаар оруулж батлуулсан байна.

Улсын барилгын хорооны 1987-1994 оны баримт бичгийг Дэд бүтцийн хөгжлийн яамны бичиг хэргийн эрхлэгч Ц.Даваасамбуу нь цэгцэлж Улсын түүхийн төв архивын дэргэдэх ББНШАЗК-ын 1996 оны 01 дүгээр сарын 26-ны 01-р хурлаар оруулж 107 хадгаламжийн нэгжийг батлуулж Үндэсний төв архивын хөмрөгт шилжүүлсэн.

Барилга, хот байгуулалтын яамны Архив болон газар хэлтсүүдээс хүлээн авсан баримт бичигт түүх эрдэм шинжилгээ, лавлагаа мэдээллийн чиглэлээр ангилан техник боловсруулалтын ажлыг 2009 оны 07-10-р сард хийсэн. Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны операторч Н.Пагмасүрэн нь Барилга, хот байгуулалтын яамны 2004-2008 оны харилцсан баримт бичгүүдийг задлан нягтлан шалгалт хийж яамны үндсэн үйл ажиллагаанд холбогдолтой баримтыг байнгад, ач холбогдлоор нь үнэлэн үлгэрчилсэн жагсаалтын дагуу түр болон устгах баримтанд, мөн санхүүгийн 2004-2008 оны харилцахын баримтнаас ажиллагсдын цалингийн карт, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн баримтыг түүвэрлэн 70 жил хадгалах баримтыг бүрдүүлсэн байна.

Барилга, хот байгуулалтын яам, Зам, тээвэр, холбооны яамны бүтэц зохион байгуулалтад 1994 онд өөрчлөлт орж уг хоёр яамыг нэгтгэн Дэд бүтцийн хөгжлийн яам болгосон тул 1994-2004 оны цалингийн картууд нь Дэд бүтцийн хөгжлийн яамны 70 жил хадгалах баримтанд бүртгэж Үндэсний түүхийн архивын дэргэдэх ББНШАЗК-ын 2008 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 11-р хурлаар батлагдсан.

Түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлд салбарын хэмжээнд мөрдөгдөх норм, дүрмийн үндсэн эх хувь нь сайдын тушаалд байгаа. Ажлын хэрэгцээнд хуулбар хувийг ҮЖ-50 д зааснаар 10 жилээр авсан болно.

Барилга, хот байгуулалтын яамны 2004-2008 оны 1 тн гаруй баримтад Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны архивын эрхлэгч Ц.Даваасамбуу түүх, эрдэм шинжилгээний ач холбогдлоор нь ангилан техник боловсруулалтын ажлыг хийж

гүйцэтгэсэн.

Баримтын эргэлтийн хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж удирдлагын үйл ажиллагаанд шинэ төрлийн баримт бичиг үүсч бий болсон. Энэхүү байнга хадгалагдах баримтын дансанд:

-Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал, Сайдын зөвлөлийн хурлын баримт, Төрийн албаны салбар зөвлөлийн тогтоол, хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр оруулсан асуудал, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, яамны үндсэн үйл ажиллагаанд хамааралтай Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, тогтоол, Ерөнхий сайдын захирамж, хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлт, гадаад оронд суугаа ЭСЯ-д, гадаад орон олон улсын байгууллагуудтай салбарын гадаад хамтын ажиллагааны талаар харилцсан бичиг, Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлан, аудитын дүгнэлт, яамны санхүүгийн үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөө, тайлан, санхүүжилт, төсөл арга хэмжээ зээлийн хөрөнгө санхүүжилт, тендерийн асуудлаар харилцсан баримт, салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ /мониторинг хийсэн ажлын тайлан/, яамны үйл ажиллагааны жилийн нэгдсэн төлөвлөгөө, тайлан, мэдээлэл, Баруун бусийн тулгуур төв Улиастай, Зуун бусийн тулгуур төв Өндөрхаан 2020 он хүртэл тогтвортой хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө танилцуулга, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэ хуваарь боловсруулах ажлын тайлан, зураглал материал судалгааны материал, Хот байгуулалт ба орон сууцны салбарын стратеги /ТТ 4352-МОН/ төслийн холбогдолтой баримт, АХБ-ны буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төслуудийн холбогдох баримт, яамны шинжлэх ухаан технологийн салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөө, тайлан, барилгын салбарын 80, 90-н жилийн төв комиссын ажлын баримт зэргүүдээс бүрдэж байна.

Байнгад, ач холбогдлоор нь үнэлэн үлгэрчилсэн жагсаалтын дагуу түр болон устгах баримтанд, мөн санхүүгийн 2004-2008 оны харилцахын баримтнаас ажиллагсдын цалингийн карт, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн баримтыг түүвэрлэн 70 жил хадгалах баримтыг бүрдүүлсэн байна.

Барилга, хот байгуулалтын яам, Зам тээвэр, холбооны яамны бүтэц зохион байгуулалтад 1994 онд өөрчлөлт орж уг хоёр яамыг нэгтгэн Дэд бүтцийн хөгжлийн яам болгосон тул 1994-2004 оны цалингийн картууд нь Дэд бүтцийн хөгжлийн яамны 70 жил хадгалагдах баримтанд бүртгэгдэж Үндэсний түүхийн архивын дэргэдэх ББНШАЗК-ын 2008 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 11-р хурлаар батлагдсан.

Баримтын эргэлтийн хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж удирдлагын үйл ажиллагаанд шинэ төрлийн баримт үүсч бий болж байна. Тус яамны архивын сан хөмрөгийн байнга хадгалах баримтад Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал, Сайдын зөвлөлийн хурлын баримт, Төрийн албаны салбар зөвлөлийн тогтоол, хуралдааны тэмдэглэл, засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр оруулсан асуудал, Мөн Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, яамны үндсэн үйл ажиллагаанд хамааралтай Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, тогтоол, Ерөнхий сайдын захирамж, хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлт, гадаад оронд суугаа ЭСЯ-д гадаад орон олон улсын байгууллагуудтай салбарын гадаад хамтын ажиллагааны талаар харилцсан бичиг,

Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн эцсийн санхүүгийн үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөө, тайлан, санхүүжилт, тендерийн асуудлаар харилцсан баримт, салбарын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ /мониторинг хийсэн ажлын тайлан/ яамны үйл ажиллагааны жилийн нэгдсэн төлөвлөгөө, тайлан мэдээлэл, АХБ-ны буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн холбогдох баримт, Яамны шинжлэх ухаан техник, технологийн салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөө, тайлан барилгын салбарын 90 жилийн ойн баримт зэргүүдээс бүрдэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 63 дугаар тогтоолоор тус яам Барилга, хот байгуулалтын яам нэртэй болж өөрчлөгдсөн.

Эрхлэх асуудлын чиглэлээр 6 газар 2 хэлтэстэй үйл ажиллагаа явуулж байгаад 2017 онд Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар шинээр нэмэгдэж байгуулсан.

Монгол Улсад барилгын салбарын бүтээн байгуулалт өдрөөс өдөрт хурдацтай хөгжиж байгаатай уялдан тус яамны баримт бичгийн эргэлтийн хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэн үйл ажиллагаа нь өргөжин тэлж 2016-2018 онд дараах тооны тушаал шийдвэр, албан бичгийг архивын баримт хадгаламжийн нэгж болгон баримтжуулсан байна. Үүнд:

1.Сайдын тушаал:

2016 онд-206; 2017 онд-219; 2018 онд-220;

2.ТНБД-ын тушаал:

2016 онд А-91; Б-252;
2017 онд А-133; Б-214;
2018 онд А-190; Б-207;

3.Албан бичиг:

2016 онд-3220, 2017 онд-3968, 2018 онд-5099 нийтдээ 14019 албан бичгээр харьяа газар төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай харилцан хамтран ажилласаар байна.

Тус яамны архивт байнга хадгалах 983, түр хадгалах 1766, яамны харьяа хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн баримт 500 нийтдээ 3350 гаруй баримт Архивын ажлын үндсэн заавар стандартын дагуу хадгалалтын хэвийн горимоор хадгалагдаж байна.

Түүхчилсэн лавлагаа бичсэн:

Архивч

Б.Мөнхтуул

